

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хуулийн төслийн зорилго нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, уул ажил дахь төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлох замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино.

Хуулийн төслийн зохицуулалт нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуультай харьцуулбал энэ хуулийн төсөл нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам, бодлогын нэгдмэл байдлыг тодорхойлоход үйлчлэхээс гадна хүчин төгөлдөр хууль гэмт хэргийн зөвхөн олон нийтийн нүдэнд ил байдаг хэсэгт буюу хулгай, дээрэм гэх зэрэг түгээмэл гэмт хэрэгтэй олон нийтийн эргүүл, харуул, жижүүр зохион байгуулах замаар урьдчилан сэргийлэх утга, агуулгатай байсныг өөрчилж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бүхий л субъектүүдээс бүхий л төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх харилцаанд үйлчлэхээр боловсруулсан.

Хуулийн төслийг боловсруулахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи судалгаа, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн одоогийн болон өнгөрсөн үеийн нөхцөл байдал, гадаад улсуудын хууль тогтоомж, гадаадын болон дотоодын эрдэмтэн, судлаачдын бүтээл, Монгол Улсын олон улсын гэрээнүүд, НҮБ, түүний салбар байгууллагуудаас гаргасан шийдвэр, зөвлөмжүүдийг судлан үзсэн.

Хуулийн төсөл нь зохицуулж байгаа харилцааны агуулга, онцлогт үндэслэн 8 бүлэгтэй байна.

Хуулийн төслийн **Нэгдүгээр бүлэгт** хуулийн төслийн зорилт, хууль тогтоомж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын тодорхойлолт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зорилго, үндсэн зарчмыг тусгана. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид Авлигын эсрэг хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай зэрэг Монгол Улсад тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх харилцаа, үйл ажиллагааг зохицуулж байгаа нийт 19 хуулийг тусгасан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчимд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид заасан зарчмууд дээр нэмж:

- гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь цогц, тогтвортой, уялдаа холбоотой байх;
- төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр нь гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан нөхцөлийг бүрдүүлэхгүй байх;

- гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээ нь судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, шинжлэх ухаан, техник, технологийн орчин үеийн ололт, амжилт, шинэ мэдлэгт үндэслэсэн байх;
- олон нийтийн оролцоонд түшиглэсэн, хэрэгцээ, шаардлагад нь нийцсэн байх;
- гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг зарчмуудыг нэмж тусгасан.

Түүнчлэн энэхүү бүлэгт анх удаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зорилгыг “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, төр, нийгэм, байгууллага, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хууль бус халдлагаас хамгаалах” гэж тодорхойлж, хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төслийн **Хоёрдугаар бүлэгт** гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тусгалаа. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн гурван чиглэлийг тодорхойлсон боловч тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хуульд ямар нэгэн зохицуулалт байхгүй бөгөөд тэдгээр арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газар батлахаар заасан байдаг.

Хуулийн энэхүү тодорхойгүй зохицуулалт нь хуулийн хэрэгжилтэд тодорхойгүй буюу сөрөг нөлөө үзүүлдэг бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын цаг хүрээг тодорхойлох боломжгүй болгодог.

Хуулийн төслөөр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндсэн таван чиглэл байхаар тусгаж, уламжлалт чиглэлүүд буюу ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн чиглэлээс гадна, эдгээр дээр нэмж анх удаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэл болон гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх чиглэлийг нэмж тусгаж, чиглэл бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой тусгалаа.

Тухайлбал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд 10, тусгай чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор 7, нэг бүрчилсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд 5, соён гэгээрүүлэх чиглэлийн хүрээнд 5, гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх үр дүнтэй бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр 8 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан.

Шинээр нэмэгдсэн соён гэгээрүүлэх чиглэлийн хүрээнд өөрийн зан үйл, дадал зуршил, эрхэлж байгаа үйл ажиллагааны онцлогоос хамааран гэмт хэрэг, зөрчилд өртөх эрсдэл бүхий хүн, хуулийн этгээдийн хүрээг тодорхойлох, тэдгээрийн гэмт хэрэгт өртөх, хохироос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгасан.

Хуулийн төслийн **Гуравдугаар бүлэгт** гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хамрах хүрээ болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг улсын болон тодорхой засаг захиргааны нэгжийн хэмжээнд уялдуулан зохицуулах талаархи зохицуулалтыг тусгасан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхдээ бодлого боловсруулах, төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх замаар зохион байгуулна.

Түүнчлэн энэхүү бүлэгт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулах арга хэлбэр, уг чиг үүргийг хэрэгжүүлэх Зохицуулах зөвлөл, салбар зөвлөл, дэд зөвлөлийн эрх хэмжээ, эрх зүйн байдлыг шинээр тодорхойлж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулах тухай зохицуулалтыг тусгасан.

Зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий субъектүүдээс хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх арга зам, үйл ажиллагааг тодорхойлж, энэхүү үйл ажиллагааны талаархи тайлан, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын нэгдмэл байдлыг хангах талаар Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Улсын ерөнхий прокурорын газартай хамтран ажиллах тухай зохицуулалтыг тусгасан.

Түүнчлэн энэхүү бүлэгт гэмт хэрэг, зөрчлийн талаархи нөхцөл байдлыг тогтоох зорилгоор гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх, хууль сахиулах байгууллагуудын албан ёсны тоо, статистикт бүртгэгдэггүй гэмт хэрэг, зөрчлийн гаралтын түвшинг тогтооход чиглэсэн зохицуулалтыг тусгаж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий алба хаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн талаархи цахим мэдээллийн сан бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл цуглуулах, боловсруулахтай холбогдсон зохицуулалтыг тусгалаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, дэд зөвлөл нь тодорхой хугацааны давтамжтайгаар гэмт хэргийн талаархи нөхцөл байдал, ажлын тайлан, цаашид авах арга хэмжээний талаар Зохицуулах зөвлөлд хүргэх, Зохицуулах зөвлөл Засгийн газар, Улсын Их Хуралд тогтмол мэдээлэл танилцуулдаг байх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тодорхой хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явуулдаг байхад энэхүү бүлгийн зохицуулалтыг боловсруулахад анхаарсан.

Хуулийн төслийн **Дөрөвдүгээр бүлэгт** гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаархи Засгийн газар, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, нутгийн захиргааны байгууллагууд болон бусад төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээд, хэвлэл, мэдээллийн оролцооны талаархи зохицуулалтыг тусгасан.

Энэхүү бүлгийн зохицуулалтаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид заасан Ерөнхийлөгчийн зохицуулах зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлах бүрэн эрхийг Засгийн газарт шилжүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын бодлого, чиглэлийг тодорхойлох бүрэн эрхийг

Засгийн газрын бүрэн эрхэд нэмж тусгасан. Түүнчлэн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд бүхий л шатны төрийн байгууллагууд тэргүүлэх үүрэгтэй оролцох талаархи зохицуулалтыг тусгаж, тэдгээрийн үүргийг шинээр өргөжүүлэн тодорхойлсон.

Хуулийн төслийн **Тавдугаар бүлэгт** гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах хэлбэрийг тусгалаа. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах нийт зургаан хэлбэрийг тусгах бөгөөд эдгээр нь урамшуулах, гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээллийг төлбөртэй авах, олон нийтийн шинэ санаачлагыг дэмжих, олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог хангах баталгааг бүрдүүлэх хэлбэртэй байна.

Түүнчлэн энэхүү бүлэгт дээр дурдсан иргэдийн оролцоог хангах хэлбэр тус бүрийн агуулга, түүний дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тусгасан нь хуулийг хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтийг хангахаар хяналт тавих, үр дүнг тооцоход чухал ач холбогдолтой бөгөөд иргэдийг урамшуулах, идэвхжүүлэх бүхий л төрлийн арга хэмжээг энэхүү бүлэгт тусгасан.

Хуулийн төслийн **Зургадугаар бүлэгт** гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдлээд суллагдсан хүнд хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг тусгалаа. Энэхүү бүлгийн зохицуулалтыг боловсруулахад одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг судалж, зөвхөн “хэлбэрийн” төдий хяналт тавьж байгааг өөрчилж, хорих байгууллагаас суллагдсан этгээдэд нийгмийн амьдралд эргэн ороход нь тусламж, дэмжлэг үзүүлэхэд илүү анхаарах, бүртгэх байдлаар хяналт хэрэгжүүлэх бус хэвийн ажиллаж, амьдрахад нь садаа болдог, залхаан цээрлүүлж байгаа байдлыг зогсооно.

Хуулийн төслийн **Долдугаар бүлэгт** гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийн талаархи зохицуулалтыг тусгалаа. Энэхүү бүлгийн зохицуулалтыг боловсруулахад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтын агуулгыг ерөнхийд нь хэвээр хадгалах боловч санхүүжилтийн хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгож, хөрөнгийг зарцуулах зориулалтыг өргөжүүлж, эдгээр зохицуулалттай уялдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сангийн талаархи зохицуулалтыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг уялдуулан боловсруулсан.

Хуулийн төслийн **Наймдугаар бүлэгт** бусад зүйл буюу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил эрхлэх болон хууль зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан ба үүнтэй уялдуулан Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.